

Тайлангийн маягтад нэмэлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.10, 77 дугаар зүйлийн 77.7.3, Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.10, 47.11, 47.19 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/164 дугаар тушаалаар батлагдсан Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлангийн маягт /ТТ-15/-д доор дурдсан агуулгатай дараах багана болон заалт нэмсүгэй.

1.1. Тайлангийн маягт /ТТ-15/-ын төлбөрийн ногдуулалтын тооцоолол хүснэгтийн Монголбанк, арилжааны банканд алт тушаасан этгээдийн суутгуулсан АМНАТ гэсний дараа “Суутгасан АМНАТ”;

1.2. Тайлангийн маягт /ТТ-15/-ын 10 дугаар хавсралтаар баталсан Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлангийн маягт /ТТ-15/-ыг нөхөх зааварт “2.9. Суутгасан АМНАТ: Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй этгээдээс ашигт малтмал худалдан авсан Ашигт малтмалын тухай хуулийн 47.1.3-т зааснаас бусад этгээд нь худалдан авсан ашигт малтмалд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг суутган авч тайлагнаж, төсөвт төлсөн АМНАТ-ийг хасаж тооцно”.

2. Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Татвар төлөгчид үйлчлэх газар /Д.Хүрэлчулуун/, тайлангийн маягтад орсон нэмэлтийг цахим тайлангийн системд нэвтрүүлэхийг Мэдээллийн технологийн төв /Х.Батбаяр/-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЗАЯАБАЛ

4. Төлбөрийн ногдуулалтын тооцоолол: /өссөн дүнгээр, төгрөгөөр/

Ашигт малтмал -ын нэр	Хэм- жих нэгж	Тоо хэмжээ	АМНАТ ногдох борлуу- лалтын нийт үнэлгээ	АМНАТ-ийн ногдуулалт			Дамжуулан борлуулагч этгээдийн өмнөх шатанд ногдуулсан АМНАТ	Монголбанк, арилжааны банканд алт тушаасан этгээдийн суутгуулсан АМНАТ	Суутгасан АМНАТ	Хасаж ногдуулсан АМНАТ (11)=(7)-(8)- (9)-(10)
				Үндсэн	Нэмэлт	Нийт				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1-р улирлын дүн										
2-р улирлын дүн										
3-р улирлын дүн										
4-р улирлын дүн										
Нийт дүн										